



**РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ  
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар П/64

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.3.10, тус газрын Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан "Хамтын гэрээ"-ний 3.11, 3.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтан, алба хаагчдад шагнал олгох журмыг нэгдүгээр, шагналд нэр дэвшигчийн анкетын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг 2024 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Захиргааны удирдлагын газар (Ц.Ганзориг)-т даалгасугай.


3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан тус газрын захирлын 2010 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 54 дүгээр тушаалаар баталсан "Оны шилдгүүдийг шалгаруулах журам", 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 17 дугаар тушаалаар баталсан "Болд агсаны нэрэмжит шагнал олгох журам", 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар баталсан "Шилдэг инженер шалгаруулах журам"-уудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ



0000110



## **“РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ШАГНАЛЫН ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. “Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын удирдлага менежментийг боловсронгуй болгох, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, радио телевизийн нэвтрүүлгийг техникийн өндөр түвшинд тасалдалгүй дамжуулж хэрэглэгчдэд хүргэх, техник тоног төхөөрөмжийн найдвартай, тогтвортой ажиллагааг хангах, ажилтан, албан хаагчдын ур чадвар, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хөдөлмөр, бүтээлийг үнэлэхэд энэхүү журмын зорилго оршино.

### **ХОЁР. ШАГНАЛЫН ТӨРӨЛ**

2.1. Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын шагнал нь дор дурдсан төрөлтэй байх бөгөөд 2.1.1, 2.1.2-т заасан шагналыг тухай бүрт, 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.6-т заасан шагналыг тухайн жилийн эцэст шалгаруулж тус тус олгоно.

- 2.1.1. Жуух бичиг
- 2.1.2. Өргөмжлөл
- 2.1.3. Оны шилдэг ажилтан
- 2.1.4. Оны шилдэг инженер
- 2.1.5. Оны шилдэг техникч, монтёр
- 2.1.6. Оны шилдэг хамт олон

2.2. Байгууллагад олон жил идэвх санаачлага, үр бүтээлтэй ажилласан ахмад ажилтан болон ажилтан, албан хаагчдыг дор дурдсан шагналд нэр дэвшүүлж, тодорхойлж болно.

2.2.1. Монгол Улсын төрийн шагнал:

2.2.2. Цахим хөгжил харилцаа холбооны яамны шагнал:

2.2.2.1. “Мэдээлэл, харилцаа холбооны тэргүүний ажилтан”

2.2.2.2. Цахим хөгжил харилцаа холбооны яамны “Жуух бичиг”

2.2.3. Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн шагнал:

2.2.3.1. Тэргүүний ажилтан цол тэмдэг

2.2.3.2. Жуух бичиг



#### 2.2.4 Харилцаа холбооны зохицуулах хорооны шагнал

##### 2.2.4.1. Хүндэт жуух бичиг

##### 2.2.4.2. Баярын бичиг

#### 2.3. Монголын залуучуудын холбооны болон бусад байгууллагын шагнал.

#### 2.4. Шагналыг дараах нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан олгоно.

##### 2.4.1. Цагаан сар;

##### 2.4.2. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажилтны өдөр;

##### 2.4.3. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр;

##### 2.4.4. Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр;

##### 2.4.5. Шинэ жил;

### **ГУРАВ. ШАГНАЛ ОЛГОХ БОЛЗОЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

3.1. Шагналыг шат дараалан, давхардуулахгүйгээр олгох бөгөөд ажлын амжилт бүтээл нь өмнөх үзүүлэлтээс ахисан нөхцөлд дараагийн шагналд нэр дэвшүүлнэ.

3.2. Байгууллагад олон жил идэвх санаачлага, үр бүтээлтэй ажилласан ахмад ажилтан болон ажилтан, албан хаагчдыг Монгол Улсын төрийн одон, медальд тодорхойлно.

3.3. Мэдээлэл холбооны салбарт, эсхүл мэдээлэл, харилцаа холбооны чиглэлийн мэргэжлээр 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж амжилтад хүрсэн мэргэжлийн туршлага, өндөр ур чадвартай ажилтан албан хаагчдыг Мэдээлэл, харилцаа холбооны тэргүүний ажилтан, Радио телевизийн тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр;

3.4. Мэдээлэл холбооны салбарт, эсхүл мэдээлэл, харилцаа холбооны чиглэлийн мэргэжлээр 10-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж амжилтад хүрсэн мэргэжлийн туршлага, өндөр ур чадвартай ажилтан албан хаагчдыг Цахим хөгжил харилцаа холбооны яамны “Жуух бичиг”, Харилцаа холбооны зохицуулах хорооны Жуух бичиг, Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн Жуух бичгээр;

3.5. Мэдээлэл холбооны салбарт, эсхүл мэдээлэл, харилцаа холбооны чиглэлийн мэргэжлээр үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдыг бусад шагналд холбогдох шагналын журмын шалгуурыг харгалзан үзэж тус тус тодорхойлно.

3.6. “Радио телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын ажилтан, албан хаагчдыг байгууллагын шагналаар шагнахдаа дараах шалгуурыг харгалзан үзнэ.

3.6.1. Шагнагдаж буй ажилтан, алба хаагч нь ажлын идэвх санаачлага, үр бүтээл, гаргасан амжилтаараа хамт олноо манлайлан ажилласан байх;

3.6.2. Технологийн горим, ХАБЭА, хөдөлмөрийн сахилгын зөрчилгүй, захиргаа, хууль хяналтын байгууллагаас ямар нэгэн арга хэмжээ авагдаагүй байх;

3.6.3. Ажлын цаг ашиглалт нь ээлжийн амралтыг оролцуулахгүйгээр 95 хувиас дээш ирцтэй ажилласан байх;

3.6.4. Тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах, ашиглалтын түвшинг дээшлүүлэх, өөрийн үйл ажиллагаанаас хамаарах гэмтэл саатал гаргалгүй ажилласан байх;

3.6.5. Шинэ техник, технологи нэвтрүүлэх, технологийн доголдолтой хэсгүүдийг сайжруулах чиглэлээр тодорхой ажил хийж үр дүнд хүрсэн байх;

3.6.6. Тухайн салбарт тогтвор суурьшилтай ажилласан байх.

### **ДӨРӨВ. ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОДОРХОЙЛОХ, ШАЛГАРУУЛАХ**

4.1. Тус газарт ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид болон өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настныг шагналд тодорхойлно.

4.2. Төвийн болон орон нутгийн салбар нэгжүүдээс холбогдох шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлж, шагналд тодорхойлсон ажилтан, албан хаагч ахмад ажилтны талаарх мэдээлэл материалыг тухай бүр тус газрын Захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.

4.3. Байгууллагын шагналаар шагнагдах ажилтан, албан хаагч, хамт олныг шалгаруулах, бусад шагналд нэр дэвшүүлж тодорхойлох ажилтан, албан хаагч, ахмад ажилтныг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

### **ТАВ. ШАГНАЛД ТОДОРХОЙЛОХОД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

5.1. Шагнуулах тухай хүсэлт гаргасан газар, салбар нэгжийн дотоод албан бичиг;

5.2. Нэр дэвшигчийн анкет (3\*4 хэмжээтэй цээж зураг);


5.3. Ажил байдлын тодорхойлолт (нэр дэвшигчийг шууд харьяалах удирдах албан тушаалтнаас тодорхойлсон байх);

5.4. Хамт олны хурлын тэмдэглэл;

5.5. Урьд нь шагнагдсан бол шагналын үнэмлэхийн хуулбар;



"Радио телевизийн үндэсний сүлжээ" Улсын  
төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2023  
оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1164  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ АЖИЛТНЫ АНКЕТ

1. Овог:
2. Нэр:
3. Төрсөн огноо:
4. Хүйс:
5. Төрсөн хот, аймаг, сум:
6. Одоогийн харьяалал:
7. Нийгмийн гарал:
8. Регистрийн дугаар:
9. Боловсрол:
10. Мэргэжил:
11. Ажил эрхэлсэн байдал:

3x4 зураг

Д/д	Ажилласан газар	Хугацаа	Албан тушаал
1			
2			

12. Ажилласан нийт хугацаа:

13. Шагнагдсан байдал:

№	Монгол Улсын цол, одон, медаль	Он	Салбар, аймаг, нийслэлийн шагнал	Он
1				
2				

14. Шагнуулах үндэслэл:

15. Шагнуулах шагналын төрөл:

16. Хамт олны саналын хувь:

17. Албан газар, байгууллагын дарга, захирал, эрхлэгчийн гарын үсэг, тэмдэг.

---ooOoo---